

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны...дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүх эрх мэдлийн байгууллагад ардчилсан, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих механизм бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн
байдлын тухай хууль тогтоомж**

2.1.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай Шүүхийн захиргааны тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“иргэдийн төлөөлөгч” гэж эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх болон шүүхийн хараат бус байдлыг баталгаажуулах чиг үүрэгтэйгээр оролцох энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа Монгол Улсын иргэнийг.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ,
ТҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА**

4 дүгээр зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх

4.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2-т зааснаар эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүх эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан /цаашид “хэрэг, маргаан” гэх/-ыг хамтран анхан шатны журмаар хянан шийдвэрлэхдээ шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулна.

4.2.Шүүхийн иргэдийн төлөөлөгч цаашид “иргэдийн төлөөлөгч” гэх/ шүүгчийн дангаар шийдвэрлэсэн шүүх хуралдаанд оролцохгүй.

4.3.Иргэдийн төлөөлөгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүх хуралдаанд оролцохдоо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.3.1.хэргийн материал, хавтаст хэрэгтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх;

4.3.2.хуульд заасан үндэслэлээр шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

4.3.3.нотлох баримтыг шинжлэхэд оролцох, нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах;

4.3.4.зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих;

4.3.5.хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруу, оноох ялын талаар дүгнэлт, тусгай санал гаргах.

5 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

5.1.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх явцад иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

5.1.1.шүүх хуралдааныг орхин явах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй байх;

5.1.2.шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэхгүй байх;

5.1.3.хэргийн оролцогчийг илт дэмжих;

5.1.4.хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзах;

5.1.5.хэргийн талаар нотлох баримт цуглуулах;

5.1.6.өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

5.1.7.хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон хэргийн талаар мэдээлэл өгөх.

5.2. Энэ хуулийн 5.1.1-5.1.7 зүйлийн хэрэгжилтэд Ерөнхий Зөвлөл хяналт тавьж, зөрчсөн этгээдийг иргэдийн төлөөлөгчөөр сонгох эрхийг 5 хүртэл жилээр хасна.

6 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчид тавих шаардлага

6.1.Энэ хуулийн 4.1-д заасны дагуу хэрэг, маргаан хянан шийдвэрлэхэд оролцох иргэдийн төлөөлөгч нь дараах шаардлага хангасан байна:

6.1.1. эрх зүйн бүрэн чадамжтай, 25 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх;

6.1.2.тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх;

6.1.3.ял шийтгүүлж байгаагүй байх;

6.1.4.сонгогдон шалгарах үедээ эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч бус байх;

6.1.5.Монгол хэлээр чөлөөтэй ярьж, ойлгодог байх.

6.1.6.сүүлийн 1 жилийн хугацаанд иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцоогүй байх.

7 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдоход хориглох зүйл

7.1.Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, шүүхийн ажилтан, прокурор, өмгөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, тухайн орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагч, онцгой байдлын албан хаагч, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргыг иргэдийн төлөөлөгчөөр сонгон шалгаруулахыг хориглоно.

7.2.Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулахдаа үндэс, арьс өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

8 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал

8.1.Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон бусад этгээдийн зүгээс иргэдийн төлөөлөгчид аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан нөхцөл байдал бий болсон гэж үзсэн тохиолдолд иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 21.1-д заасан байгууллагад гомдлоо гаргана.

8.3.Иргэдийн төлөөлөгчийн аюулгүй байдлыг тухайн шүүхийн тамгын газар хангана.

8.4.Энэ хуулийн 10.1-д заасны дагуу сонгон шалгаруулсан иргэдийн төлөөлөгчийн нэрсийг шүүгч, шүүхийн ажилтан задруулахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

9 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт

9.1.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгч сонгон шалгаруулах үлгэрчилсэн журам, иргэдийн төлөөлөгчийг сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөөг тус тус батална.

9.2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн орон нутгийн хүн амын тоог үндэслэж баталсан жишиг тоог харгалзан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг тухайн орон нутгийн анхан шатны шүүхийн тамгын газраас нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргана.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасны дагуу гаргасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт нэг жил хүчинтэй байна.

9.4.Энэ хуулийн 9.3-т заасан хугацаа дуусахаас гурван сарын өмнө шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг шинэчлэх бэлтгэл ажлыг хийнэ.

9.5.Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтад нэр нь орсон иргэнийг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан журмын дагуу мэдээллийн сан бүрдүүлнэ.

9.6.Шүүхийн ерөнхий зөвлөл ажлын хэсэг гарган иргэдийн төлөөлөгчдийн талаарх мэдээллийн үнэн зөв байдлыг шалгаж, улмаар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтыг хуралдаанаараа батална.

9.7.Шүүхийн ерөнхий зөвлөл нь иргэдийн төлөөлөгчийн оролцооны талаар судалгаа, дүн шинжилгээ, статистик мэдээг тогтмол гаргана.

10 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах

10.1.Энэ хуулийн 9.6-д заасан иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн нэгдсэн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.

10.2.Шүүхийн тамгын газар энэ хуулийн 9.6-д заасны дагуу баталсан нэрсийн жагсаалтаас 7 хоног тутам 10-15 хүний нэрсийн дэд жагсаалт гарган тухайн шүүхийн тамгын газрын даргаар батлуулах бөгөөд ингэхдээ иргэдийн төлөөлөгчдийн нас, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангасан байна.

10.3.Шүүх хуралдааны тов зарлагдмагц энэ хуулийн 10.2-т заасан дэд жагсаалтад нэр нь орсон үндсэн 3, нөөц 2 иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаан тус бүрд хуваарилна.

10.4.Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн хуваарийг тухайн шүүхийн тамгын газрын дарга батална.

10.5.Шүүх хуралдаанд оролцох тухай шүүхийн мэдэгдэх хуудсыг шүүх хуралдаан болохоос ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнд хүргүүлж мэдэгдэнэ.

10.6.Энэ хуулийн 10.5-д заасан шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авсан иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 10.10-т заасан хүндэтгэн үзэх шалтгаан байвал энэ тухайгаа тухайн шүүхийн тамгын газарт даруй мэдэгдэнэ.

10.7.Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлнэ.

10.8.Энэ хуулийн 10.7-д заасан ажил олгогч нь шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох болсон ажилтандаа чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэг хүлээнэ.

10.9.Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон иргэнийг нэг жилийн дотор дахин иргэдийн төлөөлөгчөөр сонгон шалгаруулахыг хориглоно.

10.10.Дор дурдсан хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнийг шүүх хуралдаанд оролцохоос зайлсхийсэн гэж үзэж түүнд энэ хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ:

10.10.1.эмнэлгийн магадлалаар баталгаажсан эрүүл мэндийн нөхцөл байдлын улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон;

10.10.2.ажил олгогчийн зүгээс баталгаажуулсан албан томилолттой байсан;

10.10.3.бага насны хүүхэд болон бусад этгээдийг асран хамгаалж байгаа бол энэ талаар хорооны Засаг даргын тодорхойлолттой бол;

10.10.4.хүндэтгэн үзэх бусад шалтгаантай байсан.

10.11.Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

11 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах

11.1.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч өөрөө татгалзан гарах үндэслэлийг Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тус тус тогтооно.

12 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийг татгалзан гарах үндэслэл байгаа тохиолдолд авах арга хэмжээ

12.1.Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэн шүүх хуралдаан болохоос өмнө татгалзан гарах үндэслэл байгаа тухайгаа мэдүүлэн тусгай маягт бөглөнө.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан маягтын загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

12.3.Энэ хуулийн 12.1-д заасны дагуу татгалзан гарах тухай мэдүүлсэн маягыг шалгаж баталгаажуулах ажлыг тухайн шүүхийн тамгын газар Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

12.4.Энэ хуулийн 12.1-д заасан татгалзан гарах үндэслэл тогтоогдсон тохиолдолд нэрсийн жагсаалтын дараалалд байгаа дараагийн иргэнийг иргэдийн төлөөлөгчөөр сонгон шалгаруулж авна.

13 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийг мэдээллээр хангах

13.1.Шүүхийн тамгын газар нь иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд оролцох үед эдлэх эрх хэмжээ, чиг үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгнө.

13.2.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчид зориулсан гарын авлага боловсруулж хүрэлцээтэй хэмжээгээр хэвлэн шүүхэд түгээх бөгөөд тухайн шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчдийг уул гарын авлагаар хангана.

13.3.Тухайн жилд сонгогдон шалгарсан иргэдийн төлөөлөгчдөд зориулсан нэгдсэн сургалтыг тухайн шүүхийн тамгын газраас зохион байгуулна.

13.4.Иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлыг иргэдэд ухуулан таниулах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ

14 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүн

14.1.Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчдийн тоо гурав байна.

14.2.Иргэдийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд гэр бүл, төрөл, садны холбоотой хүмүүс орохыг хориглоно.

14.3.Иргэдийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүн дутуу бол шүүх хуралдааныг хойшлуулна.

15 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч хэргийн материал, хавтаст хэрэгтэй танилцах

15.1.Иргэдийн төлөөлөгч нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу шүүх хуралдаан болохоос өмнө хэргийн материал, хавтаст хэрэгтэй танилцаж, тэмдэглэгээ хийх эрхтэй.

15.2.Иргэдийн төлөөлөгч хэргийн материал, хавтаст хэрэгтэй танилцах ажлыг шүүхийн тамгын газар зохион байгуулна.

15.3.Иргэдийн төлөөлөгч хэргийн материал, хавтаст хэрэгт байгаа мэдээллийг олон нийтэд түгээх, хэвлэл мэдээллээр мэдээлэхийг хориглоно.

16 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн санал

16.1.Иргэдийн төлөөлөгчид хамтын зарчмаар хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн болон шүүгдэгчийн гэм буруу, шүүгдэгчид оногдуулах ял, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар саналаа гаргана.

16.2.Иргэдийн төлөөлөгчид энэ хуулийн 16.1-д заасан саналаа шүүгчдийн зөвлөлдөх тасалгаанд гаргана.

16.3. Зөвлөлдөх тасалгаанд шүүгч болон иргэдийн төлөөлөгчийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргана.

16.4. Иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны үеэр гаргасан санал, дүгнэлтийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй.

17 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн тусгай санал

17.1.Иргэдийн төлөөлөгч тусгай санал гаргаж болно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан тусгай саналыг шүүхийн шийдвэрт тусгана.

ТАВДУГААР БҮЛЭГ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, ХӨЛС

18 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн талаарх бүртгэл мэдээлэл

18.1.Шүүхийн тамгын газар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан журмын дагуу тухайн жилийн иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн жагсаалт бүхий мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан сангийн мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэлтэй нэгтгэж архивт бүртгэнэ.

19 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангах

19.1.Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчдийн цагийг хэмнэх, зардал гаргуулахгүй байх зохистой арга хэмжээ авна.

19.2.Иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангах стандартыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

19.3.Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хөрөнгийг шүүхийн тамгын газарт олгоно.

20 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчид хөлс олгох

20.1.Иргэдийн төлөөлөгчийн хөлсийг шүүхийн төсвөөс олгоно.

20.2.Иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

21 дүгээр зүйл.Иргэдийн төлөөлөгчийн гомдол гаргах эрх

21.1.Иргэдийн төлөөлөгч нь шүүхийн үйл ажиллагааны талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд гомдол, мэдээлэл гаргах эрхтэй.

21.2.Иргэдийн төлөөлөгч нь дараах тохиолдолд гомдол, мэдээлэл гаргана:

21.2.1.шүүгч ёс зүйн алдаа гаргасан бол;

21.2.2.шүүхийн ажилтан ёс зүйн алдаа гаргасан бол;

21.2.3.шүүх хуралдааны дэг зөрчигдсэн бол;

21.2.4.шүүгч, прокурор, хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад этгээдээс түүнд аливаа байдлаар нөлөөлөхийг оролдсон бол.

21.3.Иргэдийн төлөөлөгчийн гомдол, мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөл 30 хоногийн дотор шийдвэрлэн бичгээр хариу мэдэгдэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

22 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

22.1.Энэ хуулийн 10.10-т заасан хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад шалтгаанаар шүүхийн үйл ажиллагаанд оролцохоос санаатайгаар зайлсхийсэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22.2.Энэ хуулийн 10.8-д заасныг зөрчсөн ажил олгогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД

23 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

23.1.Энэ хуулийг 20.. оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ